

ДеФакто **ТОЙМ**

ЗТХЯ-НЫ ЭРГЭН
ТОЙРОНД

БАНКНААС БУСАД
САНХҮҮГИЙН
САЛБАРУУД ӨСӨЛТТЭЙ
АЖИЛЛАЖЭЭ

"АЛТНЫ БОССУУД" БА
НУУЦ ЭДИЙН ЗАСАГ

VII НҮҮРТ

НИЙТЛЭЛ

ДЭЛГЭРИЙН УЯНГА

Өмгөөлөгч, хууль зүйн доктор

**ШОШГО ЗАРААД
БАЯЖМААР БАЙНА**

V НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

Алтны
ХАЛУУРАЛ

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2018.08.23, №60

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn



Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

Алтын ХАЛУУРАЛ



Гэрэл зураг: Үндэсний шуудан сонин

Алт бол хаана ч, хэзээ ч үнэ цэнээ алддаггүй цөөхөн үнэт зүйлийн нэг. 1990-ээд оны эдийн засгийн хямралыг даван гарах ганц арга нь алт гэж Ерөнхийлөгч П.Очирбат үзэж, “Алт хөтөлбөр”-ийг санаачилсан юм. 2000 оноос “Алт-2000 хөтөлбөр”, 2017 оноос Алт-2 хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд 2017 оны байдлаар нийт 200 тонн буюу 2.8 тэрбум ам.долларын үнэ цэнэ бүхий алт олборлоод байна.


Монголын эдийн засагт ийнхүү арван жил тутам алтаар “дуслын” тариа хийж ирлээ. Алтан “дусал” нь эдийн засгийг сэргээдэг ч, байгаль орчин, нийгмийн эдийн засгийн амьдралд яг ямар үр дагавар авчирч буйг нийгэм даяараа ил тод ярилцаж дүгнэх шаардлага тулгарлаа.



▶ АЛТ БА ТАТВАР

Монгол улсын экспортын орлогын дөрөвний гурвыг нүүрс, зэс, алт авчирдаг. Монголбанк 2005 онд 15 тонн алт худалдан авсан бол 2010 онд 2 тонн хүртэл буурав.

Дараа нь бага багаар буцаж өссөөр 2017 онд анх удаа 20 тоннд хүрэв. Энэ хүчтэй уналт ба сэргэлтийг төрийн татварын бодлого “бүтээжээ”.



Алтыг компаниуд ба хувь хүмүүс олборлодог. 2006 оноос гэнэтийн ашгийн татвар бий болгож 68 хувийн татвартай болгосноор алтны салбар нууц байдал руу гулсан оров. Мөн аж ахуйн нэгжийн жилийн орлого 3 тэрбумаас давсан бол 25 хувийг нь татварт авч байсан тул компаниуд алтаа хувь хүнээр дамжуулан Монголбанкинд өгөх болов. Ашигт малтмал ашигласны төлбөр 5 хувь байсан нь бас нөлөөлөв. Алтыг хууль бусаар хил давуулдаг болов. Улсын алтны нөөц багасч төгрөгийн ханш унав.

Төр бодлогоо өөрчилж 2010 оноос гэнэтийн ашгийн татварыг цуцлаж, алтны хувьд ашигт малтмал ашигласны төлбөрийг 2.5% болгон бууруулж, аж ахуйн нэгжийн орлогын дээрх татварыг таван жилээр тэглэснээр иргэд алтаа Монголбанкинд худалдах нь жилээс жилд нэмэгдсээр 2017 онд дээд амжилт тогтоож, 20 тоннд хүргэв.

Хувиараа алт олборлогчид эдүгээ монголын хөдөлмөрийн зах зээлийн томоохон хэсгийг нэгэнт эзлэх болжээ.

“Өнөөдөр албан бүртгэлтэй 8000, бүртгэлгүй гучаад мянган “нинжа” монголын өргөн уудам нутгийн хаана л алтны сураг гарна тийшээ царцаа шиг сүрэглэн нүцж, унтаж амарахыг умартан, уралдан алт ухаж, “гэдсээ өлсгөхгүй, гэртээ харихгүйгээр” донтсоор байна.”

Монголын “алтны халуурлын” ул мөрийг Заамар, Сүмбэр, Мандал, Бигэр, Ургамал зэрэг олон арван сумын нутагт үлдээсэн нүх, унаж үхсэн малын сэгээс тод харж болно.

Нинжа нар өдөртөө олсон будаа шиг алтаа шөнөдөө борлуулж, маргааш нь улам том алт олохыг мөрөөдөн улайран дайрдаг. Нинжа нарын жинхэнэ эзэд алтыг нь бэлэн мөнгөөр газар дээр нь худалдан авдаг “нууц ноёд” ажээ. Нууц ноёд алтаа бөөгнүүлэн цутгаж, аль нэг хүний нэрээр, зөвхөн 2.5 хувийн татвар төлөөд л Монголбанкинд олон улсын үнээр зарж байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх тухай нинжа нартай орон нутгийн удирдлага яриа ч гаргадаггүй, ихэнхдээ орон нутгийн удирдлага өөрсдөө энэ халуурлыг эхлүүлдэг, эсвэл дэврүүлдэг болчихоод байна.

“Алтыг хэн яаж олборлосныг шалгаж магадлахгүйгээр, татваргүй шахуу худалдан авч улсдаа үлдээх бодлогыг л монголын төр барьж байна. Үлөр өөрөө хууль журмаа мөрдүүлж чадахгүй, алтаа л алдахгүйн төлөө татварын хөнгөлөлт тусгайлан олгох болсон нь монголын “алтны халуурлын” онцлог юм.”

► ИЛ БА ДАЛД ЭДИЙН ЗАСАГ

Алтны татвар өндөр бол алт олборлогчид Монголбанкинд зардаггүй, хилээр нууцаар гаргаж, мөнгө бараа болгон хувиргаж буй нь хувь хүнээр дамжуулан ганзгын худалдааг улам бүр хөгжүүлэхэд хүргэж байна. Алт ийнхүү банкаар дамжихгүй байгаа учир мөнгөний эргэлт удааширч, далд эдийн засаг тэлдэг. Ганзгын наймаачид татвар төлдөггүй учир далд эдийн засаг улам хүчтэй болсоор байна.

Харин ил эдийн засаг буюу бүртгэлтэй бизнесүүд ажил олгосныхоо төлөө ажилчдын нийгэм эрүүл мэндийн даатгал, хувь хүний орлогын албан татвар гэх мэт цалингийнх нь гуравны нэгийг төрд шилжүүлдэг. Ганзгын наймаачид ямар ч татвар төлдөггүй мөртлөө бүх татвараа төлсөн хүний адил эрүүл мэндийн даатгалд хамрагддаг. Үр дүнд нь эрүүл мэндийн даатгалын төлбөр нь аманд ч, хамарт ч хүрдэггүй.

Алтны нууц ноёд улам томорсоор эдүгээ улс төрийн намуудын нууц санхүүжүүлэгчид болоод байна. Нэгэнт л хөгжмийг нь захиалсан учир монголын газар нутаг дээрх баялагийн олборлолтын зөвшөөрлийг төв нь үү, эсвэл орон нутаг нь шийдэх үү гэдгийг тэд зохицуулж эхэлжээ. Ямар хууль батлах, эсвэл хойшлуулахыг ч тэд удирдаж байгаа бололтой.

“Засгийн газрын шийдвэрээр бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам батлаж, нинжа нарт алт ухах зөвшөөрлийг сүм, дүүргийн засаг дарга нь олгох эрхтэй болжээ. Энэ зөвшөөрөл олгох нэрийдлээр зарим сүм, дүүргийн засаг дарга авлига авдаг, өөрсдөө ч алт ухдаг болов.”

Орон нутгийн иргэдийн хурлын гишүүд бие даасан улс мэт авирлах болжээ. Жишээ нь

Өмнөговь аймгийн нэгэн засаг дарга “аймгийнхаа газар нутгаас олдсон байгалийн аливаа баялаг юун түрүүн Өмнөговьчуудад хамаарна” гэж хэлж байв. Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тус аймгийн нутаг дэвсгэрээс уурхайн зориулалттай ус хэрэглэхийг хориглосон шийдвэр гаргаж байсан.

Ард түмний нэрийг барьж нинжа нарыг турхирдаг бүлгүүд бий болжээ. Хөвсгөл, Сүхбаатар, Баянхонгор аймгуудад нинжа нар уул уурхайн компаниуд руу дайралт хийж алт олборлож байлаа. Алтны нөөц нь тогтоогдсон уурхай хаана л байна тэнд нинжа нарын бүлгүүд аль хэдийн очдог болов. Олборлолтоо ч эхлээгүй байсан Степ Голд компанийн уурхай дээр нинжа нар бүлэглэн дайрч, ажилтнуудыг нь хөөснөөс болж Торонтогийн хөрөнгийн бирж дээр хувьцааны үнэ эрс унасан юм.

Ноён уулын алтны олборлолт гацсаныг “хууль хүчнийхэн, тэр дундаа цагдаагийнхан холбогдсон” гэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар бөөрөнхий мэдээлэл хийжээ. Цагдаа, хүчнийхэн нууц ноёдод ийнхүү үйлчилж байгаа ажээ.

Эдүгээ Монгол улсын иргэд ч, төр засаг нь ч бүхэлдээ “алтны халууралд” орчихоод байна. Төр засаг хууль журмаа сахиулж, бизнесийн орчин сайжирч, төрийн нэрээр түшмэд бизнес эрхлэхээ зогсоож, хувийн хэвшил чөлөөтэй өрсөлдөж эхэлбэл бизнес тэлж, ажлын байр нэмэгдсэнээр нинжа нар гэртээ харьж ажилтай болох юм.

2018.08.23 ■



Дэлгэрийн Уянга

Өмгөөлөгч, хууль зүйн доктор

НИЙТЛЭЛ

ШОШГО ЗАРААД БАЯЖМААР БАЙНА

Чөлөөт, шударга өрсөлдөөнийг бүрдүүлсэн зах зээлийн эдийн засагт хүн бүр өрсөлдөөнд оролцох, улмаар эдийн засгийн амжилт гаргаж, чинээлэг амьдрах боломжтой байх ёстой. Чингэхдээ төрийн хууль нь бодит үр дүн, амжилтын өрсөлдөөнийг нөхцөлдүүлж өгөх ёстой байдаг. Иймээс төрийн гүйцэтгэх нэг гол үүрэг бол бодит ажил хийж, бодит үр дүн гаргахгүй байж зүгээр суугаад мөнгө олох, бусдыг мөлжих хандлага буюу шударга бус өрсөлдөөнийг хязгаарлаж, хорих явдал юм.

Өрсөлдөөнт эдийн засгийн тогтолцооны сул тал нь өнөөдөр олсон байр суурь нь маргааш үгүй болж болно.

“Энэ баталгаатай бус байдал нь байнга хөгжих, хөдөлмөрлөх, идэвхтэй байх шахалт болдог тул зүгээр суугаад мөнгө олох хүсэлтэй хцмцст тун зохимжгүй тогтолцоо.”

Даруухан, энгийннийг нь гайхан шагширдаг гадаадын саятан хөрөнгөтнүүдийг ийм баталгаагүй, байнга ажиллуулдаг шахалттай тогтолцоо нь төрүүлж, хүмүүжүүлж байдаг. Энэ баталгаагүй тогтолцооны хамгийн гайхамшигтай давуу тал бол шинээр сэтгэн бодох, шинийг бүтээх, өрсөлдөх, уралдах хүч чадал, тэмүүллийг урамшуулж байдаг явдал. Өрсөлдөөнт эдийн засаг нь феодалын дарангуйлал, социализм нэртэй нэг намын дарангуйлал, зах зээлийн эдийн засаг нэртэй нам-компаниудын хуйвалдааны сүлжээний тогтолцооноос хамаагүй дээр тогтолцоо. Учир нь эдгээр дарангуйлал, хуйвалдааны тогтолцоонд цөөн хэд нь улс орны баялагийг дангаар захирч, дийлэнх олонх нь муу цалинтай, итгэл найдвар, сонголт багатай амьдрах ёстой болдог. Орчин цагийн нүүдэл суудал, гадаад руу дайжих хүслийг

энэ дарангуйллаас зугтаах нэг оролдлого гэж тайлбарлаж болно.

Социалист тогтолцоо нуран унаад 26 жил болж байгаа хэдий ч ихэнх монголчуудын хувьд төр нь чөлөөт, шударга өрсөлдөөнийг нөхцөлдүүлэх ёстой гэсэн ойлголт бүдэг бадаг хэвээр л байна. Бодит үр дүн, бодит хөдөлмөр, өрсөлдөөнт тогтолцоог бүрдүүлэх сэтгэлгээ дутаж байгаагийн нэг жишээ нь өнөөгийн [Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль](#).

Барааны тэмдгийн хууль нь бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, шошгыг улсад бүртгүүлэх замаар тэрхүү нэр, шошгыг дангаар эзэмших боломжийг олгодог. Бат хэмээх сэргэлэн залуу “БАТЫНХ” гэдэг нэрийг хаалга, цоожны үйлчилгээ үзүүлэхэд зориулж Оюуны өмчийн газар бүртгүүлээд, Цолмон, Жавхаа гэх мэт бусад сэргэлэн залуус “БАТЫНХ”, “БАТЫНХАА”, “БАТЫНХ ШҮҮ”, “ЖИНХЭНЭ БАТЫНХ” гэсэн нэртэй хаалга, цоожны үйлчилгээг үзүүлэхийг хориглож, дуурайн хийснийг “бут авах” боломжтой болох ёстой юм л даа.

“Бараа, бүтээгдэхүүний нэр, шошгыг дангаар өмчлөх эрхийг жишээ нь Европт хуулийн давхар шаардлага, шахалтгүйгээр төрөөс зүгээр өгдөггүй. Тухайн барааны тэмдгийн өмчлөгч нь бараа, үйлчилгээ санал болгож, улсын эдийн засагт оролцож, идэвхтэй байх цүрэгтэй байдаг.”

БАТ нь “БАТЫНХ” гэсэн шошготой хаалга, цоожоо үйлдвэрлэх ёстой, түүнийгээ худалдах үүрэгтэй. Барааны тэмдгийг бүртгүүлсний дараа таван жилийн дотор хаалга, цоожоо үйлдвэрлэж эхлээгүй бол “БАТЫНХ” гэсэн шошгын эрхээ алдаж, улсын бүртгэл нь цуцлагдаж, өөр бусад хэн нэгэн

- ийм нэрийг дахин бүртгүүлэх боломжтой болдог. Үүнийг “хэрэглэхгүй бол хүчингүй болох” нөхцөл гэдэг.

Монголын хувьд Барааны тэмдгийн хуульд “хэрэглэхгүй бол хүчингүй болно” гэсэн зүйл заалтыг оруулж өгөөгүйн дээр өнөөдөр Барааны тэмдгийн бүртгэл, шүүлт, хүчинтэй хугацааг сунгахад улсаас маш бага хураамж авдаг. Улс бүхэл бүтэн нэр, шошгын өмчлөх эрхийг үнэгүй шахам бэлэглэж байна. Энэ тогтолцооны үр дүнд бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож, улсын эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцож, ажил хийх хүсэлгүй атлаа шошгоор баяжих хүсэлтэй хүмүүсийн тоо олширсоор байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, худалдааныхан өөрийнх нь худалдсаар ирсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, шошгыг өөр нэг нь Оюуны өмчийн газар очоод аль хэдийн бүртгүүлчихсэн байхыг нэгэн өдөр олж мэдэх эрсдэл үүсэж байна. Ийм тохиолдолд эдгээр үйлдвэрлэгч, худалдаачид тэдгээр бүртгэлийн эзэдтэй барааны тэмдгийн эрх шилжүүлэх эсвэл зөвшөөрөл авах хэлэлцээр хийхээс өөр аргагүй байдалд ордог. Шинээр бизнес нээсэн эрч хүчтэй залуус бизнес хийхгүй, ажил хийхгүй байж шошго зараад, бусдыг мөлжих хүсэлтэй компанийн захирал гэгчтэй маргалдаж,

цагаа дэмий алддаг. Үүний дээр барааны тэмдгийн бүртгэлийн эзэн болсон нь “мөнгө” гэж хардаг хүмүүс ингэж бодож байгаагаасаа ичих ч үгүй хэлнэ, “би эрхтэй” гэж дайрна. Зүгээр сууж байгаад шошго зараад, бусдыг мөлжөөд амьдрах боломжийг хууль нь олгож байгаа юм чинь арга ч үгүй биз. Тэр ч бүү хэл ямар нэг бусдад танигдаж, хайрлагдсан бүтээгдэхүүний брэнд монголын зах зээл дээр бий болгоогүй байж “лицензийн гэрээ” байгуулж, жил бүр лицензийн хураамж авах “мөрөөдлөө” албан ёсоор, бат итгэлтэйгээр гэрээний нөхцөл болгож санал тавина.

“*Шошго зараад мөнгө олох итгэл нь тамга, албан тушаал зараад баяжих эсвэл зүгээр сууж байгаад уул уурхайн хишиг хүртэх ерөнхий хийрхлийн өөр нэг биежсэн хэлбэр бололтой юм.*”

Мөн бодит үр дүн, эдийн засгийн хувь нэмрийг урамшуулах чөлөөт, шударга өрсөлдөөний сэтгэлгээ, тогтолцоо бүрэлдээгүй байгаагийн нэг тод жишээ.

2018 оны 8-р сар



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь бараа, үйлчилгээний тэмдэг /цаашид “барааны тэмдэг” гэх/, газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, барааны тэмдэг



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2018.08.19-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ЗТХЯ-НЫ ЭРГЭН ТОЙРОНД

8-р сарын 9-ний оройн 21:45 цагт СБД-ийн 1 дүгээр хороонд байрлалтай Зам Тээврийн Хөгжлийн Яамны байрны гадаа хүн нас барлаа гэх дуудлага 102 утсанд ирсэн. ЗТХЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гомбосүрэнгийн амь насанд Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Б.Махбал халдсан. Шүүхээс түүнийг 30 хоног цагдан хорих шийдвэр гаргасан. Энэ хэрэг МУ-ын боловсон хүчний чанар чансааг харуулж байна. Төрийн яамдын газрын дарга нар гэдэг чинь сайдын дараа орох том албан тушаал шүү дээ. Хамтран ажиллаж байсан хүнээ цохиод амийг нь бүрэлгэчихсэн байхад хүмүүс хараад зогсож байсан гэж байгаа. Нүдэн дээр нь хүн алж байхад хүртэл хөдлөхгүй байгаа нь хүний мөс чанарын асуудлыг хөндөж байна.

Б.Махбал ЗТХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын даргын албан тушаалд 2017 оны 12-р сарын 28-нд томилогдсон. Өмнө нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Газрын даргаар ажиллаж байгаад Д.Сумъяабазар сайдын тушаалаар ажлаасаа чөлөөлөгдсөнөөр тус яаманд ажиллах болж байсан. Б.Махбалын мэдүүлсэн 2017 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн дагуу тэрээр хадгаламжиндаа 117 сая төгрөгтэй, 1.57 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгөтэй бөгөөд гэр бүлийнх нь жилийн орлого 229 сая төгрөг.

Чөлөөт зах зээлийн нэг эрх чөлөө нь хүн болгон баяжиж болно. Гагцхүү олж байгаа мөнгө нь хууль журмын дагуу л байх ёстой. Хууль журмын дагуу биш бол хэнийг ч болов зогсоох нь төрийн үүрэг. Тийм ч

болохоор бүх төрийн албаны ажилтны хөрөнгө орлогын мэдүүлгийг авдаг. Б.Махбал хэмээх энэ хүний орлогын мэдүүлгийг харахад орлогоос гадна Б.Лхамсүрэн гэдэг хүнээс авсан 500 сая төгрөгийн зээлтэй байна лээ. Энэ хүн төрд ажиллаж байсан хүн бөгөөд яах гэж зээл авсан нь сонирхолтой байгаа юм. Авсан зээлээ ямар бизнест ашигласан бэ? Тэр бизнес нь төрийн захиргааны ажил хийж байгаатай нь холбоотой юу?

Засгийн газар өөрийн мэдлийнхээ хүрээнд Зам тээврийн дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нарыг ажлын алдаа дутагдал гаргасан үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлсөн. Харин сайд Ж.Бат-Эрдэнийг чөлөөлөх эсэх асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Одоогоор Шадар сайд Ө.Энхтүвшин ЗТХ-ийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа. Тэрбээр ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын даргаар ажиллаж байсан Р.Мэргэнийг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийн түр хариуцагчаар томилсон. Энэ чөлөөлөгдөж байгаа хүмүүс нь дахиж төрийн албанд орж ирэх байх л даа. Тэгээд ч яг тэр хүн амины хэрэгт шууд оролцоогүй л бол хүний бусад эрхэд халдах хэцүү. Мөн Ерөнхий сайд өөрийн сайдаа авч ч чаддаггүй, халж ч чаддаггүй тогтолцоог харуулж байна. Үнэн хэрэгтээ МУ-ын Ерөнхий сайд 76 хүн болсон. Үр дүнд нь монголын гүйцэтгэх засаглал ямар ч эрх мэдэлгүй, зөвхөн 76 хүний хүссэн зүйлийг л хийдэг.

Монголчууд ба төрийн албан хаагчид даруу төлөв байх хэрэгтэй.

БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН САЛБАРУУД ӨСӨЛТТЭЙ АЖИЛЛАЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн болон хадгаламж, зээлийн хоршооны салбарын 2018 оны 2-р улирлын статистик үзүүлэлтүүдийг танилцуулсан.

Санхүүгийн зах зээлийг мөнгөний ба хөрөнгийн зах зээл гэж 2 хуваадаг. Мөнгөний зах зээл нь 1 жил ба түүнээс бага хугацаанд мөнгө өгч авдаг зах зээл байдаг бол хөрөнгийн зах зээл урт хугацааных. Даатгалын компаниуд урт хугацаанд мөнгө эргэлдүүлдэг тул хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд голлох үүрэгтэй байдаг. Даатгалын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 13.1

хувиар өсөн, 282.2 тэрбум төгрөгт хүрснээс 80.4 хувийг ердийн даатгалын компаниудын хөрөнгө, 16.6 хувийг давхар даатгалын компани, 3.0 хувийг урт хугацааны даатгалын компаниуд бүрдүүлжээ. Энэ бол муугүй өсөлт. Гэхдээ Люксембургт даатгалын компаниудын хөрөнгө нь эдийн засгаасаа 4 дахин том, Англид 1.7, Франц 1.7, Герман 70%, Финлянд 30%, Монголд 1.2% байна. Энэ нь даатгалын салбарт өсөх хөгжих ямар их боломж байгааг харуулж байгаа юм. Даатгалын салбар итгэл дээр суурилдаг. Гэвч одоогоор миний хувьд даатгалын компанид итгэхэд хэцүү байна л даа. 2 жилийн өмнө 5 настай машиныг маань хулгайлсан ба тэр машин 3

жил даатгуулсан байсан. Гэвч Мандал даатгал компани миний хохирлыг барагдуулаагүй үйл явдал болж байсан.

Монголын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ нь 2018 оны хагас жилээр 2.5 их наяд болсон ба өнгөрсөн жилээс 65 хувийн өсөлттэй, ДНБ-ий 10 хувийг хөрөнгийн зах зээл эзлэж байгаа юм. Дэлхийн дундаж бол хөрөнгийн зах зээл нь ДНБ-ий 115 хувь байдаг. Австрали 114, Канад 143, Хонг Конг 1274%, Польш 40% байна. Манайх 10 хувь байгаа нь чамлалтгүй эхлэл.

Банк бус санхүүгийн салбарт энэ оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 539 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагийн дийлэнх буюу 90.9 хувь нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт хөрөнгийн хэмжээ 1.14 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 33.6 хувиар өссөн бөгөөд хөрөнгийн өсөлтийн 74.1 хувийг зээлийн өсөлтөөс бүрдсэн. ББСБ ганцаараа 30 хувь өссөн байгаа ба банкны зээлийн өгч байгаа хурд нь ББСБ-г гүйцэхгүй байна л гэсэн үг. Энэ оны эхний хагас жилд бүх банкны нийт активын хэмжээ 30.2 их наяд төгрөгт хүрсэн байна.

Үүнийг нэг жилийн өмнөхтэй харьцуулвал 13 хувиар өссөн дүн. 30 их наяд төгрөгийн хагас нь дотоод зээл, бүх зээлийн 1.3 хувь нь чанаргүй зээл. Монголын банкуудын ихэнх зээл 1 жилээс их хугацаанд байдаггүй тул банк мөнгөний зах зээлд байгаа. Мөнгөний зах зээл анх удаа ДНБ-ээс давсан буюу (2017 онд ДНБ 27.2 их наяд төгрөг) банкны мөнгө 10 хувиар илүү явж байна. Францад гэхэд л банкуудын нийт актив эдийн засгаасаа 4 дахин том байдаг, Англид 3.7 дахин том, Орост 90 хувьтай тэнцдэг ба МУ-д 110 хувьтай тэнцэж буюу Чили улстай тэнцэж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны салбарт нийт 289 хоршоо хоёрдугаар улиралд үйл ажиллагаа явуулжээ. Салбарын нийт цэвэр ашиг 1.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 30.6 хувиар буурсан байгаа бол нийт орлого 37.4 хувиар өсөж 19.3 тэрбум төгрөг буюу сүүлийн 10 жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн байна.

"АЛТНЫ БОССУУД" БА НУУЦ ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк өнгөрсөн долдугаар сард 2,132 кг алт худалдан авснаар энэ оны эхнээс хойш нийт 9.34 тонн алт худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үед 8.94 тонн алт авч байснаас 399 кг-аар их буюу 4 хувиар өссөн үзүүлэлттэй юм. 7-р сарын байдлаар 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 97 883.50 төгрөг байв. Монгол улсын экспортын орлогын дөрөвний гурвыг нүүрс, зэс, алт авчирдаг. Алт нь валютын нөөц, монгол төгрөгийн баталгаа болж байгаа юм л даа. Монголбанк 2005 онд 15 тонн алт худалдан

авсан бол 2010 онд 2 тонн хүртэл буурав. Дараа нь бага багаар буцаж өссөөр 2017 онд анх удаа 20 тоннд хүрсэн. Алтыг компаниуд болон хувь хүмүүс олборлодог. Алтны компаниудыг байгаль орчинд ээлтэй байлгахын тулд янз бүрээр шахаж болж байгаа. Харин нинжа нарыг шахаж дийлдэг хүн алга. Шинэ алтны компани гарч ирмэгц, алт байгаа газрыг мэдмэгцээ л нинжа нарыг оруулчихдаг "алтны боссууд" байна. Монголын төр засаг хуулийн дагуу алт олборлох уу, хууль бусаар алт олборлох уу гэдэг асуултад хариулах ёстой болж байна.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв

Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.



NEW NISSAN PATROL

9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84**сар


УРАМШУУЛАЛ:






Хамгааллын хууль Сансар сервисын арх 4x4 Өвлийн дугуй Салони шигшээ хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette

➤ АНГЛИ

➤ МОНГОЛ

➤ ЯПОН



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
 Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
 Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
 Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com